

”ӨЛЗИЙДУНДГОВЬ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ

ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ШИЙДВЭР

2022 оны 03-р сарын

16-ний өдөр

№ 02

Мандалговь

“Өлзийдундговь” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн
ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 60.1дэхь заалт, Санхүүгийн Зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 тоот тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх” журмыг үндэслэн **ШИЙДВЭРЛЭХ НЬ:**

1. “Өлзий Дундговь” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2021 оны ээлжит хурлыг 2022 оны 04-р сарын 29-ны өдрийн 16.00 цагт Дундговь аймгийн Сайнцагаан сумын 7-р баг Буяаннэмэхийн өргөн чөлөө-2 200 тоотод байрлах “Өлзийдундговь” ХК – ийн байранд хуралдуулсугай.

2. “Өлзийдундговь” ХК -ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар доор дурьдсан асуудлыг хэлэлцэхээр тогтоосугай.

- Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, аудитийн дүгнэлт
- Компанийн хувьцаа эзэмшигчдэд 2021 оны санхүүгийн үр дүнгээр ногдол ашиг хуваарилахгүй тухай ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах

3. Энэхүү ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийг тасалбар болгон бүртгэх өдрийг 2021 оны 04 дүгээр сарын 05-ний өдрөөр тогтоосугай.

4. Компанийн ээлжит хурал хуралдуулах шийдвэр гарсантай холбогдуулан хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдэд хүргэх хурлын зарыг” Өдрийн сонин”гийн 2021 оны 03-р сарын 21-ны даваа гарагийн дугаарт, давтан зарыг мөн сонины 4-р сарын 05-ний өдрийн дугаарт нийтлүүлж зарлуулахыг ТУЗ-ийн дарга /Н.Буянхүү/-д даалгасугай.

5. Хурлын зар өгөхтэй холбоотой зардлыг гаргаж өгөхийг санхүүд зөвшөөрсүгэй.

6. Ээлжит хурлыг хуралдуулахтай холбогдуулан хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчид нь хавсралт 1-д заасан бичиг баримттай 2022 оны 3-р сарын 24-ний өдрөөс эхлэн компанийн байранд болон Санар ҮЦК-ийн байранд ажлын өдрүүдэд 10-17 цагт ирж танилцах эрхтэй болохыг дурьдсугай.

7. Компанийн ээлжит хурлыг удирдах даргаар Н.Буянхүүг, нарийн бичгийн даргаар Н.Баярсүрэн нарыг тус тус томилсугай.

8. Тооллогын комиссын даргаар А.Өлзийбалжирыг, гишүүдэд Х.Төмөрсумъяа, Д.Мөнх-Очир нарыг тус тус томилсугай.

9. Хурал хуралдуулах тухай тогтоолыг гаргаснаас хойш 3 хоногийн дотор “Өлзийдундговь” ХК-ийн “Хувь нийлүүлэгчдийн хурлын мэдэгдэл”-ийг Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржид хүргүүлэхийг хурлын даргад даалгасугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



Н.БУЯНХҮҮ